

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.3.24 дэх заалтыг нэмсүгэй:

“5.3.24.Хүүхдийн төлөө сан.”

**2 дугаар зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21<sup>2</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

21<sup>2</sup>. Хүүхдийн төлөө сан

21<sup>2</sup>.1 Хүүхдийн төлөө сан нь хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжлийг дэмжих зориулалттай байна.

21<sup>2</sup>.2. Сангийн хөрөнгийн эх үүсвэр нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-оос гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

21<sup>2</sup>.2.1. автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаарын борлуулсан орлого;

21<sup>2</sup>.2.2. хүүхдийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн соёл урлаг, спортын тоглолтын орлого, хандив;

21<sup>2</sup>.2.3. гадаад улс, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон хандив, тусламж;

21<sup>2</sup>.2.4. хувь хүн, хуулийн этгээдээс өргөсөн, хандив, буцалтгүй тусламж;

21<sup>2</sup>.2.5. бусад эх үүсвэр.

21<sup>2</sup>.3. Сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

21<sup>2</sup>.3.1. хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжих;

21<sup>2</sup>.3.2. тив, дэлхийн соёл, урлагийн болон спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах.

21<sup>2</sup>.4. Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг хуулийг 2021 оны .... сарын ... -ны өдрөөс дагаж мөрдөнө.